

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН 2015 ОНЫ АВЛИГААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр

№	Хийх ажлын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн байдал /гүйцэтгэл/
Нэг. Хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх			
1.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа танилцуулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/</p> <p style="text-align: center;">/Нотлох хавсаргав/ баримтыг</p>	<p>2015 оны МИД-ын борлуулалтын үед сурталчилгаа хийх ажлын төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлын 2015 оны 04/22 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлсэн.</p> <p>1. Компани дээрээ мэдээллийн самбар захиалан байрлуулж ерөнхий мэдээлэл болон нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл тус б мүрээс сүүлийн үеийн мэдээлэл байршуулсан.</p> <p>2. 2014 оны 11 дүгээр сард www.agreinsurance.mn хийсэн цахим хуудсаа шинэчлэн сайжруулж загвар, хийц, агуулгын хувьд өөрчлөн баяжуулсан. Сүүлийн 6 сарын байдлаар сард дунджаар 270 орчим хэрэглэгч хандсан байна.</p> <p>Малын индексжүүлсэн даатгалын тухай болон компанийн тухай мэдээллийг малчдад тухай бүр хүргэх, даатгалын ашиг тусыг ойлгуулах зорилгоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нэртэй фэйсбүүк пэйж нээн хөтлөх ажлыг эхлүүлсэн бөгөөд 21 аймгийн хамгийн олон хандалттай</p>

			<p>пэйж хуудсуудтай хамтран ажиллах санал тавин ажиллаж байна.</p> <p>3. Малын индексжүүлсэн даатгалын ашиг тус, дэлхийн банкны хэрэгжүүлж байсан МИД-ын төслийн үйл ажиллагааг тус компани үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа талаар 42 секунд, 48 секунд, 1 минут 28 секундийн 3 шторкийг “EYESLENZ” студиэр бэлтгүүлэн хийлгэж 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн “Малчин ТВ”-ээр тус бүр өдөрт 2 удаагийн давтамжтайгаар нийт 12 удаа, мөн 42, 48 секунд, 1 минут 28 секундийн 3 шторкийг бэлтгүүлэн хийлгэж 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн “Малчин ТВ”-ээр тус бүр өдөрт 2 удаагийн давтамжтайгаар нийт 12 удаа, мөн 42, 48 секундийн шторкийг МҮОНРТ-ээр 6 дугаар сарын 10-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийн өмнө өдөр бүр цацсан.</p> <p>Цагийн хүрд нэвтрүүлгээр нээлттэй хэлэлцүүлэгт компанийн ТУЗ-ын гишүүн Л.Чой-Иш МИД-ын тухай ярилцлага өгсөн ба “Малчин ТВ”, “Роял ТВ”, Сэвэн ТВ-ээр 7 хоногийн мэдээний тоймд хамтран ажиллагч даатгалын компаниудын болон тус компанийн төлөөлөл тус бүр 1 ярилцлага өгсөн нэвтрүүлэг давтамжтайгаар хүрсэн.</p> <p>МҮОНРадиоогийн “Ая дууны мэнд” нэвтрүүлгээр ТВ-ийн Notebook дээр малын индексжүүлсэн даатгалд хамрагдах уриа, компанийн логог байршуулсан. Мөн “Малчны хотонд” нэвтрүүлгээр малын индексжүүлсэн даатгалд идэвхитэй хамрагддаг малчин Б.Анхбаярын гэрт очиж ярилцлага авч 5 дугаар сарын 26, 28-ны өдрүүдэд нэвтрүүллээ.</p> <p>4. Гүйцэтгэх захирал Блүмберг телевизэд 10 дугаар сарын 20-ны өдөр 2 удаа, Малчин телевизэд 6 сарын 20-ны өдөр 1 удаа, газрын дарга Т.Оюунбат, андеррайтер М.Мөнхсүвд, Ц.Мандах-Эрдэнэ нар 6 дугаар сарын 16, 20, 24, 27-ны өдрүүдэд тус бүр Малчин телевизэд 1 удаа, нийт 3 удаа компанийн үйл ажиллагааг танилцуулах,</p>
--	--	--	--

			<p>бүтээгдэхүүнийг сурталчилах зэргээр 20 минутын теле ярилцлага өгсөн.</p> <p>5. 2015 оны 6 дугаар сард Баянхонгор аймагт болсон “1000 малчны өдөрлөг”-ийг зохион байгуулахад оролсон.</p> <p>6. 2015 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр даатгалын зуучлагч банктэй хэрхэн хамтран ажиллах талаар даатгалын компаниудын төлөөлөгчидтэй компани дээрээ хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулж санал бодлыг нь сонсож шийдвэрлэсэн.</p> <p>7. Борлуулалтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд цаг тооны бичиг, бүтээгдэхүүний танилцуулга товхимол болон малчдад зохиулсан сонинг хэлүүлэн оролцогч даатгалын компаниуд, даатгалын төлөөлөгчдөөр дамжуулан тараасан.</p> <p>Компанийн танилцуулга, гарын авлагыг 20 мянган ширхэгийг хэвлэн оролцогч даатгалын компаниудаар дамжуулан тараасан.</p>
		<p>1.2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх, бүртгэл хөтлөх</p>	<p>Авлигатай тэмцэх газраас Сангийн яамны эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан ирүүлсэн АТГ-аас бэлтгэн гаргасан ХАСХОМ бүртгэх, хадгалах ЭБАТ-ны гарын авлагыг авч ашиглаж байгаа ба “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”-ыг ажилтан бүрт өгч танилцуулсан. Мөн Авлигын эсрэг сурталчилгааны 4 плакатыг мэдээллийн самбарын дэргэд байршуулж нийтийн хүртээл болголоо.</p>
<p>2.</p>	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч</p>	<p>2.1. Боловсруулж байгаа Хувь нийлүүлэгчийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх, цахим хуудсанд тусгай цонх үүсгэх</p>	<p>Компанийн цахим хуудасны “Ил тод байдал” цонхонд “шийдвэрийн төсөл” гэсэн нэмэлт цонх үүсгэн бодлогын шинжтэй шийдвэрийн төслийг байршуулдаг.</p>

	бүлгүүдтэй харилцан санал солилцох		
		2.2. Боловсруулж байгаа Хувь нийлүүлэгчийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын төслийг цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй санал солилцох	Компанийн цахим хуудасны “Ил тод байдал” цонхонд “шийдвэрийн төсөл” гэсэн нэмэлт цонх үүсгэн бодлогын шинжтэй шийдвэрийн төслийг байршуулж МИД-ын бүтээгдэнүүнийг борлуулдаг даатгаг компани болон даатгалын төлөөлөгчдөд танилцуулахын зэрэгцээ тодорхой асуудлуудаар и-майл хаягаар тэдэнтэй харилцаж шаардлагатай санаа оноог солилцдог.
3.	Төсвийн орлого, түүний зар-цуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх, цахим хуудсанд байршуулах	3.1.Тухайн жилийн төсөв	2015 оны төсвийг 3 дугаар сарын 15-ны өдөр байршуулсан.
		3.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	2014 оны 9 дүгээр сард байгуулагдсан бөгөөд тухайн оны төсөв гэж батлаагүй болно.
		3.3. Сарын төсвийн гүйцэтгэл	Төрийн өмчит аж ахуйн нэгж учраас хуулийн даруу улирлаар гаргаж байна. Улирлын тайлантай хамт дараа улирлын 25-ны дотор байршуулсан.
		3.4. Улирлын төсвийн гүйцэтгэл	
		3.5. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл	7 дугаар сарын 25-ны өдөр байршуулсан
		3.6. Дараа жилийн төсвийн төсөл	2016 оны төсвийн төсөл 11 дүгээр сарын 30-нд бэлэн болох бөгөөд улсын төсвийн байгууллага бус тул цаашид энэхүү хэсгийг асгачлалаас хасуулах саналтай байна.
		3.7. Хагас жилийн санхүүгийн тайлан	2015 оны хагас жилийн санхүүгийн тайланг 8 дугаар сарын 11-ний өдөр вэбд байршуулсан.
		3.8. Жилийн эцсийн санхүүгийн тайлан	2014 оны жилийн эцсийн тайланг 3 дугаар сарын 30-ны өдөр байршуулсан.
		3.9. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	2014 оны жилийн эцсийн аудитын тайланг 3 дугаар сарын 30-ны өдөр байршуулсан.

	3.10. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Дүгнэлтийн дагуу 2015 оны 1 дүгээр улирлын тайланг бэлтгэсэн.	
	3.11. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Хэтрэлт байхгүй бөгөөд хэмнэлт жилийн эцсийн тайлангаар гаргах тул энэхүү тайланд тоо тавих боломжгүй юм.	
	3.10. тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор буюу 2015 оны 8 дугаар сарын 17–ны өдөр байршуулсан	
	3.11. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгэний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт		
	3.12. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Тус орлого, зарлагын мөнгөн гүйлгээг хийгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор холбогдох мэдээллийн хамт тус тус байршуулсан.	
	3.13. байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс батласан бүтэц орон тоонд өөрчлөлт ороогүй болно.	
	3.14. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	ТУЗ-ийн 2014 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 02/06, 2015 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 02/30 дугаар тогтоол болон Гүйцэтгэх захирлын 2015 оны 26-ны өдрийн 04/75 дугаар тушаалаар шийдвэрлэсэн 17 тэрбум төгрөгийг Засгийн газрын үнэт цаасанд байршуулсан талаар баримтыг байршуулсан.	

		3.15. Тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт	Аливаа хараат болон охин компани байхгүй болно.	
		3.16. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Тус компанид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээд байхгүй болно.	Нягтлан бодогч
4.	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	4.1. Байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах	Аливаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, лиценз олгодоггүй болно.	
		4.2. Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах	Аливаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, лиценз олгодоггүй болно.	
		4.3. Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Аливаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, лиценз олгодоггүй болно.	

		<p>4.4. Аливаа үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор бусад байгууллагаас олгосон зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх г.м бусад үйл ажиллагаа эрхлэх/, түүний талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах</p>	<p>1.Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газраас 2014 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр олгосон 9010001126 улсын бүртгэлийн дугаартай, 5885612 регистрийн дугаартай, 0000088364 тоот гэрчилгээг давхар даатгалын үйлчилгээ эрхлэн явуулахаар олгосон.</p>	<p>Гэрчилгээний хуулбарыг хавсаргав.</p>
			<p>2. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 01 дүгээр сарын 21–ний өдрийн 48 дугаар тогтоолоор давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.</p> <p>Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний огноо 2015.01.21. дугаар № 220/02</p>	<p>СЗХ-ны тогтоол болон ТЗ-ийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав</p>
<p>5.</p>	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p>	<p>5.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гишүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Гүйцэтгэх захирал, Ерөнхий хуульч, Санхүү удирдлагын газар, Давхар даатгалын газар, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар, Бизнес хөгжил төслийн газрын дарга нар болон нягтлан бодогч, худалдан авалт хариуцсан ажилтан нарын танилцуулгыг цахим хуудсандаа байршуулах</p>	<p>Компанийн шинэчлэн сайжруулсан цахим хуудасны “Бидний тухай” гэсэн цонхонд “ТУЗ, Гүйцэтгэх удирдлага” гэсэн хэсэгт эдгээр албан тушаалтнуудын товч танилцуулга, мэдээллийг тавсан болно.</p>	
		<p>5.2. Энэхүү аргачлалын 9.1.5.1-д заасан ажилтны хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах</p>	<p>Дээрх албан тушаалтнуудын хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан гүйцэтгэх ажил, үүргийн чиглэлийг цахим хуудасны “Бидний тухай” гэсэн цонхонд “ТУЗ, Гүйцэтгэх удирдлага” гэсэн хэсэгт байршуулсан болно.</p>	

		<p>5.3. Боловсон хүчнийг сонгон шалгаруулах журмыг цахим хуудсандаа байршуулах</p> <p>Хүний нөөцийн сонгон шалгаруулатын гормыг “Менежментийн төлөвлөгөө”-нөөс авч нотлох баримтаар хавсаргав.</p>	<p>Компанийн бизнес төлөвлөгөөний 2.6-д “Менежментийн төлөвлөгөө” гэсэн хэсэгт Хүний нөөцийн хэрэгцээ сургалтыг тусгасан. Албан хаагчдыг ажлын байранд сонгон шалгаруулахдаа Анкетын шалгаруулалт, Ярилцлага, Мэргэжлийн ур чадвар тогтоох шалгалт, Удирдлагатай хийх уулзалт, Туршилтын хугацаагаар ажиллуулах, Баримжаа олгох сургалтад хамруулах, Үндсэн ажилтнаар гэрээ байгуулах гэсэн шат дамжлагаар авах бөгөөд компанийн цахим хуудасны “Ил тод байдал” цонхны “Үйл ажиллагааны ил тод байдал” гэсэн хэсэгт байршуулсан болно.</p>	
		<p>5.4. Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/</p>	<p>Сул орон тоо гараагүй, учир нь 2005 оноос хэрэгжиж ирсэн Дэлхийн банкны төслийн ажилчид шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулан шилжиж ирсэн.</p>	
6.	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p>	<p>6.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах</p> <p>6.2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерт оролцохыг сонирхогчид тавиах шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах</p> <p>6.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулах</p> <p>6.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах</p>	<p>ТУЗ-ийн 2015 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 02/29 дүгээр тогтоолоор 2015 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсныг компанийн цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Бартаат замыг туулах чадвартай суудлын автомашин нийлүүлэх тендерийн урилга, тахиx шалгуур, үзүүлэлтийг ЗГ-ын худалдан авах ажиллагааны e-procurement.mof6 gov.mn сайт болон “Улс төрийн тойм” 2015.8.21-нд тавьсан.</p> <p>Бартаат замыг туулах чадвартай суудлын автомашин нийлүүлэх тендер шалгаруулах үнэлгээний хороо 2015.9.01-ний өдөр хуралдаж нийлүүлэгчээр “Таванбогд” ХХК шалгарсан. Өөр компани оролцоогүй.</p> <p>5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтын хэмжээг байршуулсан.</p>	<p>Нотлох баримт шаардлаггүй</p> <p>Тендерийн хорооны дарга болон Худалдан авалт</p>

		6.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах	2014 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг цахим хуудсанд байршуулсан. Хяналт шалгалт ороогүй.	хариуцсан ажилтан
		6.6. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд “Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв” ТББ-ын 2 төлөөлөгчийг оролцуулсан.	
7.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	7.1. Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх	Гүйцэтгэх захирлын 2015 оны 8 дугаар сарын 12-ны өмрийн 04/52 дугаар тушаалаар О.Батбилэгийг ХАСХОМ-ийг бүртгэх, хадгалах, хянах эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-аар шинэчлэн томилсон.	Тушаалыг хавсаргав
		7.2.ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах	Гүйцэтгэх захирлын 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдөр батлагдаж дуудагдсан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Ерөнхий хуульчийн ажлын байрны тодорхойлолтын “7 дугаар зорилтын хүрээ”-нд тусгагдсан болно.	Ажлын байрны тодорхойлолтыг хавсаргав
		7.3.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх	ЭБАТ-аар томилогдсоноос хойш АТГ-аас аливаа сургалтад дуудаагүй. Харин Санхүүгийн зохицуулах хорооны ЭБАТ байхдаа хангалттай сайн хамрагдаж Үндэсний хөтөлбөр боловсруулах Ажлын хэсэгт орж байсан.	
8.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	8.1. Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас санал авч тусгах	Дараа нь ёс зүйн дүрмийн төсөлдөө АТГ-ын саналыг тусгах шаардлагатай талаар зөвлөмж ирүүлсний дагуу батлагдсан журамд санал авахаар албан бичгээр тус байгууллагад хүргүүлэхэд АТГ-аас 2015 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 03/5717 тоот	АТГ-ын албан тоот, Гүйцэтгэх захирлын 2015 оны 10 дугаар сарын 26–ны өдрийн

			албан бичгээр 6 зүйл бүхий саналыг тусгуулахаар ирүүлсэн. Үүний дагуу Гүйцэтгэх захирлын 2015 оны 10 дугаар сарын 26–ны өдрийн 04/79 дүгээр тушаалаар холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан болно.	04/79 дүгээр тушаалыг хавсаргав
		8.2. Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/	Хөдөө аж ахуйн давхар даатгал“ ХК-ийн Ёс зүйн дүрэм”-ийг Гүйцэтгэх захирлын 2015 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 04/43 дугаар тушаалаар баталж ажилтнуудад 7 дугаар сарын 30–ны өдөр “Чингисийн хүрээ” resort газарт зохион байгуулсан сургалтан дээр танилцуулсан.	Сургалтын тайланг хавсаргав
		8.3. Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх	Зөрчил гараагүй	
		8.4. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх	Энэ хугацаанд ёс зүйн аливаа зөрчил илрээгүй бөгөөд нэмэлт, өөрчлөлтийн талаар болон дүрмийн хэрэгжилтийн байдлын талаар нийт ажилтнуудад дотоод сүлжээгээр болон сургалтан дээр танилцуулсан болно.	
9.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах /төрийн болон байгууллагын нууцад хамаарахаас бусад/, цахим хуудсандаа байршуулах	9.1. Удирдлагын шийдвэр /Хувь нийлүүлэгчдийн Хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаал/-ийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/ 9.2.Хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолыг цахим хуудсандаа байршуулах 9.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг цахим хуудсандаа байршуулах	Компанийн цахим хуудасны “Хууль, эрх зүй” гэсэн цонхонд “Тогтоол тушаал” гэсэн хэсэгт байршуулдаг. Компанийн цахим хуудасны “Хууль, эрх зүй” гэсэн цонхонд “Тогтоол тушаал” гэсэн хэсгийн “Хувь нийдүүлэгчийн шийдвэр” гэдэгт байршуулдаг. Компанийн цахим хуудасны “Хууль, эрх зүй” гэсэн цонхонд “Тогтоол тушаал” гэсэн хэсгийн	Компанийн цахим хуудсанд байршуулсан тул нотлох баримтаар хүргүүлэх шаардлагүй.

			“Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол” гэдэгт байршуулдаг.	
		9.4. Гүйцэтгэх захирлын тушаалыг цахим хуудсандаа байршуулах	Компанийн цахим хуудасны “Хууль, эрх зүй” гэсэн цонхонд “Тогтоол тушаал” гэсэн хэсгийн “Гүйцэтгэх захирлын тушаал” гэдэгт байршуулсдаг.	
10.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	10.1. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, хууль тогтоомж /хуульчилсан акт/ 10.2. Засгийн газар, яамд, Төрийн өмчийн хорооны шийдвэр 10.3. Компанийн дүрэм, дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, заавар 10.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, хянан шалгах зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс, урамшууллын хэмжээ 10.5. Ноогдол ашгийн хувь, хэмжээ, хувьцаа эзэмшигчдэд олгосон хуваарилалт 10.5. Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ /ТӨХ болон холбогдох байгууллагатай/	Компанийн цахим хуудасны “Хууль, эрх зүй” гэсэн цонхны “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт нийт 9 хууль байршуулсан. Компанийн цахим хуудасны “Хууль, эрх зүй” гэсэн цонхны “Эрх бүхий байгууллагаас батласан дүрэм журам” гэсэн хэсэгт байршуулсан. Компанийн цахим хуудасны “Хууль, эрх зүй” гэсэн цонхны “Дотоод дүрэм журам” гэсэн хэсэгт байршуулсан. Компанийн цахим хуудасны “Хууль, эрх зүй” гэсэн цонхны “Тогтоол тушаал” гэсний “Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол” гэдэгт байршуулсан. 2014 оны 9 дүгээр сард Засгийн газрын шийдвэрээр үүсгэн байгуулсагдсан тул ногдол ашгийн хуваарилалт байхгүй. Компанийн цахим хуудасны “Хууль, эрх зүй” гэсэн цонхны “Тогтоол тушаал” гэсний “Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол” гэдэгт Гүйцэтгэх захирлыг томилсон тогтоолын хамт байршуулсан.	Компанийн цахим хуудсанд байршуулсан тул нотлох баримтаар хүргүүлэх шаардлаггүй.
11.	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх	11.1. Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (<i>утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр</i>) 11.2. Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан	Компанийн захиргааны ажилтан өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг бүртгэн авч шийдвэрлэх ажлыг шат шатанд зохион бйагуулдаг. Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааран өргөдөл гомдол харьцангуйгээр цөөн ирдэг ба үүсгэн байгуулагдсан цагаас хойш нэг ч ирээгүй байна. Компанийн цахим хуудсанд “Холбоо барих” цонхонд харилцах утас, и-майл, бусад	Захиргааны ажилтны ажлын байрны тодорхойлолтыг хүргүүлэв Олон нийттэй харицах

	мэдээллийг хүлээн авч шалгах	тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	шаардлагатай холболтын хаягийг байршуулсан. Энэхүү ажлыг компанийн олон нийттэй харилцах ажилтан хэрэгжүүлдэг бөгөөд түүний ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан болно.	ажилтны ажлын байрны тодорхойлолтыг хүргүүлэв.
		11.3. Иргэдийн өргөдөл /санал, мэдээгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх	Иргэдээс аливаа өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл ирээгүй бөгөөд ирсэн тохиолдолд энэхүү аргачлалын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр шийдвэрлэсэн талаар цацах нь Хувь хүний нууцын тухай хуулийг зөрчих, мөн ач холбогдолгүй учир хасах нь зүйтэй.	
12.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	12.1. Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх	10 дугаар сард багтаан компанийн Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалын жагсаалтыг гаргахдаа нийт ажилтнуудын дунд судалгаа явуулсан. Судалгаагаар зарим Гүйцэтгэх захирал болон бусад зарим албан тушаалтыг дурьдсан.	/Жагсаалт болон судалгааны дүнг хүргүүлэв/
		12.2. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирээдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдээгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/	2015 оны 7 дугаар сарын 30–ны өдөр “Чингисийн хүрээ” resort амралтын газарт сургалт зохион байгуулж уг сургалтаар Компанийн дүрэм, Дотоод журам, Ёс зүйн дүрэм, Мэдээллийн аюулгүй байдлын журам зэргийг болон Төрийн өмчит компанийн хувьд Компанийн тухай хуулиас гадна Авлигын эсрэг хууль, НАНБХАСЗТХууль, холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллах шаардлагатайг тайлбарлан танилцуулсан.	Сургалтын тайланг хавсаргав.
13.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	13.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	1. АТГ-аас 2015 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 03/5717 тоот албан бичгээр компанийн Ёс зүйн дүрэмд 6 зүйл бүхий саналыг тусгуулахаар ирүүлсэн.	Гүйцэтгэх захирлын 2015 оны 10 дугаар сарын 26–ны өдрийн

		<p>Үүний дагуу Гүйцэтгэх захирлын 2015 оны 10 дугаар сарын 26–ны өдрийн 04/79 дүгээр тушаалаар холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан болно.</p> <p>2. Сангийн яамны ЭБАТ-аар дамжуулан 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлсэн Авлигатай тэмцэх газрын 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 05/6887 тоот албан бичгийн нэг, хоёрдугаар хавсралтаар ирүүлсэн судалгааг компанийн нийт ажилчдаас авч харъяалах даргаар нь хянуулан заасан хугацаанд нь буюу 11 сарын 11-ний өдөр хүргүүлсэн болно.</p>	<p>04/79 дүгээр тушаалыг хавсаргав.</p> <p>АТГ-ын албан бичиг болон саналын хуудас, нэгтгэлийг хавсаргав.</p>
	<p>13.2.АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ</p>	<p>Аливаа мэдэглэл ирээгүй</p>	
	<p>13.3. АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ</p>	<p>Аливаа зөрчил гараагүй</p>	
	<p>13.4. АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт</p>	<p>Авлигатай тэмцэх газраас энэ талаар албан тоот ирүүлээгүй</p>	

		13.5. Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох талаар авсан арга хэмжээ	Сангийн сайдын 2014 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 192 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн дүрэм”-ийг Сангийн сайдын 2015 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 35 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Мөн шинэчлэн батлагдсан дээрх журамд Сангийн сайдын 2015 оны 4 дүгээр сарын 23-ний өдрийн 96 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан.	Өөрчлөлт оруулсан Сангийн сайдын шийдвэрийг хавсаргав.
Хоёр. Авлигатай тэмцэх санал, санаачилга				
14.	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	14.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах	Гүйцэтгэх захирал 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Компанийн 2015 оны авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	Төлөвлөгөөг хавсаргав.
		14.2. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг цаг, хугацаандаа хэрэгжүүлэх	Төлөвлөгөөнд Авлигатай тэмцэх газрын саналыг цахимаар авсан бөгөөд нийт 17 төрлийн 69 ажил төлөвлөснөөс хэрэгжээгүй ажил байхгүй, бүрэн бүрэн биелэсэн.	Тайлан албан бичгээр хүргүүлэв.
		14.3. Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд АТГ-т хүргүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд буюу 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн ... тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн болно.	
		14.4.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх Энэ талаар тайланд заавал тусгах	1. Нотлох баримт шаарддаг явдал нь ихээхэн чирэгдэлтэй байдаг. Цахим харилцаа хөгжсөн энэ үед скайнердсан хувийг авахад хангалттай. 2. Аливаа шийдвэрийн төслийг цахим хуудсанд тавьж сонирхогч бүлгүүд, олон нийтээс саналыг авах асуудал ямар ч үр дүн байхгүй ажил байдаг.	

			<p>Сонирхогч бүлгүүд болон олон нийт зөвхөн өөрийн эрх ашиг хөндөгдөхөөр асуудлаар санал, бодлоо хуваалцдаг бөгөөд шийдвэр гаргах этгээд ч хууль зөрчөөгүй, урт настай зохицуулалт, шийдвэр гаргахын тулд хамаарах этгээдүүдийн саналийг цахим шуудан болон албан тоотоор баталгаажуулан авдаг ба энэ нь илүү үр дүнгтэй, ажил хэрэгч байдлаар зохицуулагддаг.</p> <p>3. Энэ их баримт бичгийг АТГ-тай гэрээтэй Төрийн бус байгууллага гүйцэтгэхэд чанарын ямар шалгуур тавигддаг нь тодорхойгүй. Өмнө нь өөр байгууллагад ЭБАТ байхдаа нотлох баримтаар өгсөөр байхад 5 баримт материалыг дутуу өгсөн хэмээн дүнгэлтэндээ тусгаж, гомдол гаргах боломжит хугацаагүйгээр оноог дутуу дүгнэж дулимаг шийдвэр гаргаж байсныг нэгтгэсэн хуралд дээр танилцуулж байсан.</p> <p>4. Иргэдээс аливаа өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэлийн шийдвэрлэсэн байдлыг энэхүү аргачлалын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах нь Хувь хүний нууцын тухай хуулийг зөрчих, мөн ач холбогдолгүй учир хасах нь зүйтэй. Аливаа компанийн хувьд бүр ч шаардлаггүй юм.</p> <p>5. Аргачлалаа оновчтой болгож байгаа нь анзаарагдаж байгаа боловч дээрх байдлаар улам бүр цэгцтэй, төгс болгох шаардлага байгаа нь энэхүү тайланг гаргах явцад анзаарагдлаа.</p> <p>6. Дэлхий нийтээрээ цааснаас татгалзаж буй өнөө үед нотлох баримтыг цаасаас авдаг байдлыг халж цахимаар цэгцтэй байдлаар тодорхой загвар заавар гарган авдаг байх.</p>
15.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх	15.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга	<p>Монгол улсын засгийн газрын хуралдаанаас өгсөн чиглэлийн хүрээнд тус компани ТУЗ-ийн гишүүдийн урамшууллыг бууруулаад зогсохгүй эдийн засгийн хямралтай байдлыг харгалзан төсвийн зарлагыг бууруулах</p> <p>ЗГ-ын шийдвэр, ЗГХЭГазар, АТГ, Сангийн</p>

	хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	/уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал	зорилгоор компанийн удирдлага хэлэлцээд ажилчдынхаа сарын үндсэн цалинг 20 хувиар бууруулахаар шийдвэрлэн хэрэгжүүлж байна.	яам, ТУЗ-ын тогтоол, албан бичгүүдийг хавсаргав.
		15.2.Удирдах алба тушаалтны авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал /Компанийн нийт ажилчдад Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүний талаар ойлголт өгөх сургалтыг зохион байгуулах/,	Компанийн удирдлагын зүгээс санаачлан 2015 оны 8 дугаар сарын 14-ний өдөр “Малын индексжүүлсэн даатгалын үндсэн ойлголт” сэдвээр ажилчдад сургалт зохион байгуулж 27 ажилчдаас 23 нь олцсон. Сургалтын дараа дээрх сэдвээр мэдлэг сорих тестээр шалгалт авч дүгнэсэн. Энэхүү сургалтыг ирэх оны төлөвлөгөөнд уламжлан тусгаж хэрэгжүүлж байхаар шийдвэрлэсэн.	Шалгалтын талаарх баримтыг хавсаргав.
		15.3.Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/ /Авлигын эсрэг авах арга хэмжээний хүрээнд самбар хэвлүүлэн баяжуулж байршуулах/,	2015 оны 9 дүгээр сарын 01-ны өдөр “Дуут нутгийн ивээл” ХХК-д Компанийн мэдээллийн самбарыг 250 000 төгрөгөөр захиалан хийлгүүлж компанийн байрны үүдний хэсэгт байрлуулсан. Энхүү самбарын мэдээллийг нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлсэн ажил болон холбогдох шинэ мэдээллээ сар бүр хариуцан шинэчлэн оруулж байна.	Самбар хийлгэсэн баримт болон самбарын зургийг авч хүргүүлэв
16.	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	16.1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах	Гүйцэтгэх захирлын санаачлагаар 2015 оны 7 дугаар сарын 30–ны өдөр “Чингисийн хүрээ” resort амралтын газарт сургалт зохион байгуулж уг сургалтаар Компанийн дүрэм, Дотоод журам, Ёс зүйн дүрэм, Мэдээллийн аюулгүй байдлын журам зэргийг болон Төрийн өмчит компанийн хувьд Компанийн тухай хуулиас гадна Авлигын эсрэг хууль, НАНБХАСЗТХууль, холбогдох дүрэм, журмыг	Сургалтын тайланг хавсаргав.

			мөрдөж ажиллах шаардлагатайг тайлбарлан танилцуулсан.	
17.		16.2.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ	Ажилчдын ажлын гүйцэтгэлийн үр дүнг улирал бүр цаасаар болон цахимаар авч гарын үсэг зурж баталгаажуулан жилийн эцэст шударга зарчмыг баритлан тухайн ажилтныг байлцуулан нэгтгэн дүгнэж байхаар шийдвэрлэсэн.	3 ажилтны илтгэх хуудсыг жишээ болгон хүргүүлэв.

Жич: Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил авсан арга хэмжээнд +10 оноо, бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээнд -5 оноо, Шүүхээр шийдэгдсэн, Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчилд -5 оноо өгч үнэлэгдэхийг анхаарна уу.

ТАЙЛАН ГАРГАСАН: ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН О.БАТБИЛЭГ